



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хүүхдийн номын өргөөний  
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Хүүхдийн номын өргөөний дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаанд нь хяналт тавьж, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдуулан шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, хэрэгжилт үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 01 сарын 08-ны  
өдрийн 01 тогтоолын хавсралт



## **“ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ӨРГӨӨ”-НИЙ ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Чингэлтэй дүүргийн Хүүхдийн номын өргөөний зорилго нь сургуулийн өмнөх болоод сургуулийн насныхан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрэгцээт ном, хэвлэлээр нь түргэн шуурхай, соёлтой үйлчлэх, гадаад дотоодын хүүхдийн уран зохиол, ерөнхий мэдлэгийн хичээлийн сурах бичгүүдийг бүрдүүлэн хадгалах, бүртгэл мэдээллийн сан бий болгох, номоор дамжуулан хүүхэд багачуудыг хөгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх хөгжлийн төв болоход оршино.

1.2 Чингэлтэй дүүргийн хүүхдийн номын өргөө /цаашид “номын өргөө” гэх/ нь орон нутгийн төсвөөс санхүүждэг, тус дүүргийн Засаг даргын харьяа төрийн өмчийн төсөвт байгууллага юм.

1.3 Номын өргөө нь үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад хууль тогтоомж болон батлагдсан дүрмийг удирдлага болгоно.

1.4 Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны цогцолбор байр

1.5 Номын өргөө нь өөрийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

1.6 Номын өргөөний дэргэд уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн дэмжлэгийг авах, тэдний зүгээс номын өргөөний үйл ажиллагаанд тавих хяналтыг өргөжүүлэх зорилгоор соёл боловсрол, хүүхэд багачуудын болон олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий орон тооны бус “Номын өргөөний зөвлөл” ажиллуулж болно.

### **Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, сургуулийн өмнөх насныхан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон Ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх

2.2 Шинэ, соргог эрэлт ихтэй орчин үеийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр номын өргөөний сан хөмрөгийг баяжуулах

2.3 Номын өргөөний үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх арга барил хэрэглэх

2.4 Гадаад орны номын сангуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх номын сан хоорондын номын солилцоог хэрэгжүүлэх

2.5 Хүүхдүүдийг номд дуртай, номтой нөхөрлөх, номоор дамжуулан тэднийг хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

2.6 Номын өргөөнд номын сангийн автоматжуулсан програмыг нэвтрүүлэх

### **Гурав. Номын өргөөний эрх, үүрэг**

#### **3.1 Номын өргөө нь дор дурдсан эрх эдэлнэ.**

3.1.1 Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын зөвшөөрлийг үндэслэн номын өргөөний хэрэгцээнээс илүү ном хэвлэлийг солилцох, худалдах, худалдан

авах, утга агуулга, эдэлгээний улмаас хуучирсан ном, хэвлэлийг данснаас хасч, номын эргэлтийг сайжруулах

3.1.2 Төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах

### **3.2 Номын өргөө нь дор дурдсан үүрэг хүлээнэ.**

3.2.1 Уншигч /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдүүдээс тогтмол судалгаа авч, хэрэгцээт номын жагсаалтыг үндэслэн шинээр хэвлэгдсэн бүх төрлийн ном, хэвлэл, аудио, видео бичлэг, кино хальс, диск, дижитал материалыг бүрдүүлж, гадаад улсад хэвлэгдсэн чухал хэрэгцээт ном хэвлэлийг худалдан авах, номын солилцоо хийх зэргээр номын өргөөний сан хөмрөгөө арвижуулах

3.2.2 Номын өргөөний номзүйн мэдээллийг автоматжуулах, лавлагаа мэдээллийн санг бий болгох.

3.2.3 Номын өргөөний бүртгэл мэдээлэл, номын каталог, хайлтыг автоматжуулах.

3.2.4 Номын өргөөний сан хөмрөгт хадгалагдаж буй ном хэвлэлийг зохих журмын дагуу уншигчдад ашиглуулах, каталог, картын сан, электрон мэдээллийн сангийн тусламжтайгаар байгууллага, иргэдэд төрөл бүрийн мэдээллээр үйлчлэх.

3.2.5 Гадаад орны номын сангууд болон холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах, ажлын туршлагыг судлан нэвтрүүлэх

3.2.6 Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөлд хамрагдах, хамтран ажиллах замаар номын өргөөний үйл ажиллагааг боловсронгуй болгох

3.2.7 Хүүхэд хөгжүүлэх төрөл бүрийн уралдаан тэмцээнийг санаачлах, зохион байгуулах

3.2.8 Жил бүр үйл ажиллагаагаа өргөжүүлж, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэн ажиллана.

3.2.9 Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнан үр дүнг тооцон ажиллана.

### **Дөрөв. Удирдлагын тогтолцоо бүрэн эрх**

4.1 Номын өргөө нь Эрхлэгч, Номын санчдаас бүрдэнэ.

4.2 Номын өргөөний үйл ажиллагааг Эрхлэгч удирдана. Эрхлэгчийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлнө.

4.3 Батлагдсан бүтэц орон тооны хязгаарын саналаа боловсруулан Засаг даргаар батлуулан ажиллана.

### **4.3 Эрхлэгч дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.**

4.3.1 Батлагдсан төсөвтөө багтаан ном хэвлэл худалдан авах, Номын өргөөний үйл ажиллагааг тогтмолжуулна.

4.3.2 Ажилтныг ажилд томилох, чөлөөлөх саналыг Тамгын газарт уламжлах, санал болгох

4.3.3 Номын өргөөний ажиллах журам, ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ баталж, мөрдүүлэх

4.3.4 Номын өргөөг төлөөлж байгууллага, иргэнтэй гэрээ хэлэлцээр байгуулах

4.3.5 Номын өргөөний үйлчилгээний орчинг сайжруулах, ажилтнуудын ажиллах нөхцлийг бүрдүүлэх

4.3.6 Барилга байгууламж, тоног төхөөрөмж, сан хөмрөгийн аюулгүй байдлыг хангах

4.3.7 Номын өргөөний ажлын төлөвлөгөө батлах, Засаг даргын Тамгын газарт тайлан мэдээг илтгэх

4.3.8 Номын өргөөний ажилтнууд номын өргөөг хөгжүүлэх, үйлчилгээний орчинг сайжруулах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд номын өргөөний эрхлэгчид дэмжлэг туслалцаа үзүүлэх

4.4.9 Дэлхийн зөн Олон улсын байгууллагаас хэрэгжүүлдэг “Хүний хөгжлийн төв” дээр ажиллаж буй номын санчийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

4.4.10 Номын өргөө нь хороодод бичил номын сантай байх бөгөөд мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

#### **Тав. Үйлчилгээний хүрээ, ажлын цагийн үргэлжлэл**

5.1 Номын өргөө нь дор дурьдсан хүрээний уншигчдад үйлчилнэ.

5.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид

5.1.2 Хүүхэд багачууд

5.1.3 Тус дүүргийн оршин суугч хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

5.1.4 Сургуулийн өмнөх насныхан

5.2 Номын өргөө нь “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хууль”-д заасан нийтээр тэмдэглэх баярын өдрүүдээс бусад өдрүүдэд 7 хоногийн 5 өдөрт ажиллана.

➤ Ажлын цагийн үргэлжлэл 08.30-17.30 цаг

➤ Цайны цагийн үргэлжлэл 12.30-13.30 цагийн хооронд байна.

➤ Номын санчид амралтын өдөр буюу Бямба гарагт 10.00-18.00 цагийн хооронд ажиллана. Амралтын өдөр ажиллах хуваарийг дотоод журмаараа зохицуулна.

#### **Зургаа. Номын өргөөний эд хөрөнгө, санхүү**

**6.1 Номын өргөөний эд хөрөнгө нь дор дурьдсан зүйлсээс бүрдэнэ. Үүнд:**

6.1.1 Барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад эд материал

6.1.2 Ном, сонин, сэтгүүл, хэвлэмэл бус материалууд

**6.2 Номын өргөө нь дор дурьдсан эх үүсвэрээр санхүүжинэ.**

6.2.1 Улсын төсөв, орон нутгийн төсөв

6.2.2 Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж

6.2.3 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого

6.2.4 Олон Улсын байгууллагын төсөл, хөтөлбөр

6.2.5 Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

□ Чингэлтэй дүүргийн хороодын гудамж, □  
байранд нийтийн эргүүл ажиллуулах журам

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төр, иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэх, гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах зорилгоор Хороодын гудамж, байранд нийтийн эргүүл ажиллуулах журмыг хавсралт ёсоор баталсугай.

1. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын  
08-ны өдрийн 02 дугаар тогтоолын  
хавсралт



## **ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХОРООДЫН ГУДАМЖ, БАЙРАНД НИЙТИЙН ЭРГҮҮЛ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар иргэд, оршин суугчид нэгдэж, амьдарч буй орчиндоо амар тайван, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх, энэ ажилд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хороодын гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь Монгол Улсын “Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх тухай хууль”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан “Хөршийн хяналт” хөтөлбөр, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан “Амар тайван Чингэлтэй” хөтөлбөр болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэхүү журмыг баримтлан ажиллана.

Хоёр. Зорилго

2.1. Дүүргийн иргэд, оршин суугчдын идэвх, санаачлагад суурилсан хяналтыг бий болгож, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалт

3.1. Хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь гудамж, байр бүрээс сайн дурын үндсэн дээр тухайн гудамж, байрны байнгын оршин суугч иргэнийг нийтийн эргүүлээр ажиллуулахаар сонгон шийдвэр гарган, бүртгэлжүүлэн ажиллуулна.

3.2. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүлд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үнэмлэх олгох бөгөөд таних тэмдэг, туг дарцаг хэрэглүүлж болно.

3.3. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүлд тухайн хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Хэсгийн байцаагч болон Иргэний танхимын ажилтан мэргэжил арга зүйн удирдлагаар

хангах бөгөөд тухай бүр шуурхай мэдээ мэдээлэл, чиглэл өгөх, улирал тутам сургалтанд хамруулах, шаардлагатай гарын авлага, материалаар хангана.

3.4. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүлийн ажлыг тухайн хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн саналыг үндэслэн сар бүр 15000 хүртэл төгрөгөөр шагнаж болно.

3.5. Хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дарга гудамж, байрны нийтийн эргүүлийг шагнах саналаа илтгэх хуудсаар сар бүрийн 20-ны өдрийн дотор дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ирүүлнэ.

3.6. Нийтийн эргүүлийг шагнах, чадавхижуулах, сургалт зохион байгуулах, сайн туршлагыг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилахад шаардагдах санхүүжилтийг Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс санхүүжүүлнэ.

Дөрөв. Хороодын гудамж, байранд ажиллах нийтийн эргүүлийн эрх, үүрэг

4.1. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь өөрийн идэвх санаачлагаа дайчлан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, цаг үеийн асуудлыг иргэдэд шуурхай сурталчилан мэдээлэх

4.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд болон гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, бусад зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай дамжуулж, хамтран ажиллах.

4.3. Үйл ажиллагааныхаа чиглэлээр айл өрх, иргэд, нутаг дэвсгэрийн байгууллагуудад шаардлага тавих, асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал гаргах.

4.4. Нутаг дэвсгэрийнхээ иргэдийн эрүүл аюулгүй байдал, амьдрах орчин нөхцлөө сайжруулах, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар гудамж, байрны хуралдаанаас гарсан айл өрх, иргэдийн санал санаачлагыг хэрэгжүүлэхэд орон нутгийн Төрийн болон Төрийн бус байгууллагуудаас дэмжлэг туслалцаа хүсэх, хамтран ажиллах.

Тав. Хүлээлгэх хариуцлага.

5.1 Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

┌ Хороодын Иргэдийн Нийтийн Хуралд ┐  
дэмжлэг үзүүлэх журам

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр тогтоолын 1.12 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Хороодын Иргэдийн Нийтийн Хуралд дэмжлэг үзүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ





## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХОРООДЫН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх, туршлага судлуулах, хамтран ажиллах замаар нутгийн удирдлагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, чадавхийг нь бэхжүүлэх мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, мэдээ мэдээллийг шуурхай хүргэх, сурталчилах байнгын тогтолцоог бүрдүүлж, бүхий л талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **Хоёр. Мэдээ мэдээллээр хангах, сургалтын талаар**

2.1. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг сар тутам мэдээ мэдээллээр хангаж, ажлын шаардлагыг нь харгалзан зорилтот болон захиалгат сургалтад хамруулахыг Хурлын Ажлын алба хариуцан зохион байгуулах.

2.2. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар, Тэргүүлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах.

2.3. Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар туршлага солилцох, иргэдэд хорооны үйл ажиллагаатай танилцах боломжийг бүрдүүлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, байнгын тогтмол үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

### **Гурав. Шагнах, урамшуулах талаар**

3.1. Нутгийн өөрөө удирдах ёсыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх үйлсэд идэвх зүтгэл гарган ажилласан хорооны Иргэдийн Нийтийн Хурлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр жилд нэг удаа Өргөмжлөл, 500.0 мянга хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулж болно.

3.2. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга төрийн дээд цол хүртэж, одон медалиар шагнуулсан бол 100.0 мянга хүртэл төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгч болно.

3.3. Хариуцсан ажилдаа идэвх зүтгэлтэй, амжилт гаргаж ажилласан Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдийг 300.0 мянган хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулж болно.

### **Дөрөв. Дэмжлэг үзүүлэх**

4.1. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын ажиллах орчин нөхцөл, техник тоног төхөөрөмж, шаардлагатай бичиг хэргийн материалаар Хурлын ажлын

4.1. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын ажиллах орчин нөхцөл, техник тоног төхөөрөмж, шаардлагатай бичиг хэргийн материалаар Хурлын ажлын албанаас хангах ба Хороодын Иргэдийн Нийтийн хурлаас хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

4.2. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга хүндээр өвчилсөн мөн Монгол улсад эмчилгээ оношлогоо хийгдэх боломжгүй тохиолдолд эрх бүхий байгууллагын дүгнэлтээр гадаад улсад эмчилгээнд явах шаардлагатай тохиолдолд 3.0 сая хүртэл төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж болно.

4.3. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нас барсан бол түүний ар гэрт 1.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж болно.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Шагналд уламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

**МОНГОЛ УЛСЫН “ГАВЪЯАТ БАГШ ЦОЛ”-ООР:**

- |                             |   |
|-----------------------------|---|
| 1. Цэрэндоржийн Өлзийжаргал | Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн захирал |
|-----------------------------|---|

**МОНГОЛ УЛСЫН “СОЁЛЫН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН” ЦОЛ-ООР:**

- |                            |   |
|----------------------------|---|
| 1. Бүдрагчаагийн Чимэддорж | “Парагон медиа” ХХК-ийн зөвлөх найруулагч |
|----------------------------|---|

**“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР:**

- |                           |   |
|---------------------------|---|
| 1. Пүрэвдоржийн Батбаатар | Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга |
| 2. Дэмбэрэлийн Начинсүрэн | Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан     |

**“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:**

- |                               |  |
|-------------------------------|--|
| 1. Дамбийбалжирын Цэвээнсүрэн | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан |
| 2. Цэрэнхандын Лхагва         | Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга    |

3. Янсанжавын Жаргалсайхан	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга
4. Самбуугийн Эрдэнэбулган	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
5. Аюушийн Мөнхчимэг	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн захирал
6. Дэмэдийн Дулмаа	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 49 дүгээр сургуулийн бага ангийн багш
7. Лажиймарын Энхтуяа	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн ахмад багш
8. Батсүхийн Сарангэрэл	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургуулийн Математикийн багш
9. Довдоншаравын Нармандах	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн бага ангийн багш
10. Дашвандангийн Туяа	“Алтжин бөмбөгөр” ХХК-ийн Дэд захирал

#### **“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:**

1. Жанчигбалын Сарантуяа	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн Физикийн багш
2. Шаравын Дарьдулам	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн бага ангийн багш
3. Дашдаваагийн Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн Түүх, нийгмийн ухааны багш
4. Чойнхорын Урангоо	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн Математикийн багш

5. Дагвын Түмэнжаргал	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 39 дүгээр сургуулийн Сургалтын менежер
6. Лхагвацэрэнгийн Бадамцэцэг	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 39 дүгээр сургуулийн бага ангийн багш
7. Дашпунцагийн Уранчимэг	Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэгийн арга зүйч
8. Даваасамбуугийн Сугар	Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш
9. Пунцагийн Дарьсүрэн	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн Биеийн тамирын багш
10. Сономын Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн Биологийн багш
11. Санжийн Наранцэцэг	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн бага ангийн багш
12. Тогтоолын Пүрэвсүрэн	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн Технологийн багш
13. Мажигийн Уранболор	Чингэлтэй дүүргийн 31 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш
14. Тумбаагийн Цогзолмаа	Чингэлтэй дүүргийн 31 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш
15. Авирмэдийн Гэрэлмаа	Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 117 дугаар сургуулийн Математикийн багш
16. Жимээгийн Наранчимэг	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш
17. Дамдингийн Энхтуяа	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Ахлах тогооч

18. Батсуурийн Даваасүрэн

Дүрслэх урлагийн музейн Үзмэр  
харагч

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ